

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ
ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ГҮЙЦЭТГЭЛ

АУДИТЫН КОД: ӨМА-2022/20-10-НА-СТА

СОНГУУЛИЙН ЗАРДЛЫГ ХЭМНЭЛТТЭЙ ЗАРЦУУЛСАН БАЙНА

Даланзадгад хот 2021 он

Дарга, Тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Аудитор Ч.Наранбадрах

Утас: 70533552 Цахим хаяг: Naranbadrakhch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хаяг: www.audit.mn

Аудитыг гүйцэтгэсэн:	Агуулга	Хуудас
Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр Аудитын менежер Т.Хонгорзул Аудитор Ч.Наранбадрах	Товчилсон үгийн тайлбар	5
	Хүснэгт, график, дүрслэл, бүдүүвчийн жагсаалт	6
	Бүлэг 1. Сумдын ИТХ-ын 2022 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журам, зориулалтын дагуу төлөвлөж хуваарилсан байна.	7-9
	Бүлэг 2. Сумдын ИТХ-ын 2022 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан байна.	9-12
Дүгнэлт		13
Зөвлөмж		14
Тэргүүлэх аудиторовын тушаал		15
2022 оны 7 дугаар сар		
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70533539, 70533552 дугаарын утсаар харилцана уу.		
Тайланг ӨМТАГ-ын www.umnugovi@audit.gov.mn цахим хуудаснаас үзнэ үү.		
Хаяг: Нутгийн удирдлагын ордон, 3 давхар, 303 тоот.		

Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудит хийх Үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/34 дугаар тушаалыг үндэслэн “Орон нутгийн Хурлын нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэл”-д Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

Орон нутгийн Хурлын нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэл дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан АСХ, ҮАГ, холбогдох байгууллагад танилцуулж, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэв.. Үүнд:

- Орон нутгийн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх
- Орон нутгийн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх

Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймаг, сумын сонгуулийн хороо, хэсгийн хороодыг хамруулав.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 3000-3100, Монгол Улсын Төрийн аудитын стандарт-Гүйцэтгэлийн аудит MNS 6817-7:2020, Нийцлийн болон Санхүүгийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсруулав. Аудитын хөтөлбөрийг орон нутгийн онцлогт тохируулан боловсруулав.

Аудитад ашигласан шалгуур:

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хууль
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль

**Аудит хийсэн
багийн
бүрэлдэхүүн**

**Аудитын
хугацаа**

- Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль
Дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан тогтоол, журам

Аудитыг газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Т.Хонгорзул хэрэгжүүлж, аудитор Ч.Наранбадрах гүйцэтгэв.

Аудитыг 2022 оны 06 дугаар сарын 19-ны өдрөөс 07 дугаар сарын 08-ны өдөр хүртэл хугацаанд хэрэгжүүлэв.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АСХ	Аймгийн Сонгуулийн хороо
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МТБ	Мэдээллийн технологийн баг
СЕХ	Сонгуулийн Ерөнхий Хороо
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар

Хүснэгт, график, дүрслэл, бүдүүвчийн жагсаалт

Хүснэгт-1 Аймгийн сонгуулийн хорооноос аймаг, сумдын сонгуулийн хороонд баталсан төсөв

Хүснэгт-2 Аймгийн сонгуулийн хорооноос аймаг, сумдын сонгуулийн хороонд баталсан төсөв зардал тус бүрээр

Хүснэгт-3 Аймаг, сумдын ИТХ-н 2022 оны нөхөн сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны хэмнэлтийг зардал тус бүрээр

Хүснэгт-4 Сумдын ИТХ-н 2022 оны нөхөн сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэлийг зардал тус бүрээр

Хүснэгт-5 Сумдын ИТХ-н 2022 оны нөхөн сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэлийг сум тус бүрээр

Хүснэгт-6 Сумдын ИТХ-ын нөхөн сонгуулийн Улсын бүртгэлийн хэлтсийн зардал

Хүснэгт-7 Цагдаагийн газрын 2022 оны сумдын ИТХ-ын нөхөн сонгуулийн зардал

График-1 Сумдын ИТХ-н 2022 оны нөхөн сонгуулийг зохион байгуулах үйл ажиллагааны зардлын санхүүжилт

График-2 Сумдын ИТХ-н 2022 оны нөхөн сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны зардлын хэмнэлт

График-3 Сумдын ИТХ-н 2022 оны нөхөн сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны зардлын хэмнэлтийг аймаг, сумдаар харуулбал

График-4 Сумдын ИТХ-н 2022 оны нөхөн сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэл

БҮЛЭГ А Улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журам, зориулалтын дагуу төлөвлөж хуваарилсан байна.

1. Улсын төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцож олгосон байна




1.1 Сонгуулийн Ерөнхий Хорооны 2021 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай” журмын дагуу аймаг, сумдын сонгуулийн хороо, салбар комисст зардлыг тооцож олгосон байна.

**БАТАЛСАН
ТӨСӨВ**

100%

**ОЛГОСОН
САНХҮҮЖИЛТ**

/График-1/ Сумдын ИТХ-ын 2022 оны нөхөн сонгуулийг зохион байгуулах үйл ажиллагааны зардлын санхүүжилт /сая.төгрөг/



Эх сурвалж: Аймгийн нөхөн сонгуулийн хорооны 2022 оны тайлан

Сонгуулийн ерөнхий хорооны ажлын албанаас сумдын ИТХ-н 2022 оны нөхөн сонгуулийн үйл ажиллагааны зардлыг 2022 оны 04 дүгээр сарын 21-нд эхний хэсгийн санхүүжилтийг, 06 дугаар сарын 07-нд 2 дахь хэсгийн санхүүжилтийг баталсан төсвийн хуваарийн дагуу хүргүүлсэн байна.

2. Сонгуулийн хороодод зардлын төсвийг үндэслэлтэй тооцож хуваарилсан байна

2.1 Аймгийн сонгуулийн хороо нь Сонгуулийн Ерөнхий Хорооны 2021 оны 3 дугаар сарын 19-ны А/17 дугаар тушаалаар “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам” СЕХ-оос өгсөн албан бичиг, заавар, зөвлөмжийн дагуу аймаг, сумдын сонгуулийн хороодын зардлыг тооцож хуваарилсан байна.

Хүснэгт №- 1 Аймгийн сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн хороонд баталсан төсөв /сая.төгрөг/

№	СОНГУУЛИЙН ХОРООНЫ НЭРС	БАТАЛСАН ТӨСӨВ
1	Даланзадгад сумын сонгуулийн хороо	1.7
2	Баян-Овоо сумын сонгуулийн хороо	1.7
3	Булган сумын сонгуулийн хороо	1.7
4	Мандал-Овоо сумын сонгуулийн хороо	1.7
5	Номгон сумын сонгуулийн хороо	1.5
6	Аймгийн сонгуулийн хороо	59.8
	НИЙТ	68.1

Эх сурвалж: Аймгийн нөхөн сонгуулийн хорооны 2022 оны тайлан

Хүснэгт №-2 Өмнөговь аймгийн сонгуулийн хорооны баталсан төсвийн зардал /сая.төгрөг/

№	ЗАРДЛЫН НЭР	БАТАЛСАН ТӨСӨВ
1	Маягт хэвлүүлэх зардал	0.1
2	Үнэмлэх хэвлэх зардал	0.2
3	Сонгуулийн хорооны сургалтын зардал	0.8
4	МТБ, даамлын сургалтын зардал	0.1
5	Бичиг хэргийн зардал	1.6
6	Шуудан холбооны зардал	2
7	Унааны зардал	6.3
8	Санал авах байр бэлтгэх зардал	1.5
9	Саналын хуудас, ICP төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх унаа, томилолтын зардал	7.6
10	МТБ-ийн мэдээ дамжуулах холбоо, унааны зардал	0.2
11	САС ашиглах холбоотой гарах зардал /Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх/	0.4
12	Мэдээ дамжуулах унааны зардал	0.3
13	Сурталчилгааны зардал	3
14	Томилолтын зардал	3.9
15	Сонгуулийн хорооны гишүүний урамшуулал, хоолны зардал	31.9
16	Мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	5.7
17	Болзошгүй зардал	2.5
	НИЙТ	68.1

Эх сурвалж: Аймгийн нөхөн сонгуулийн хорооны 2022 оны тайлан

2.2 Аймгийн сонгуулийн хороо нь СЕХ-ны Ажлын албаны 2022 оны 4 сарын 21-ны өдрийн 3/51 тоот, 2022 оны 6 сарын 7-ны 3/82 тоот, СЕХ-ны ажлын албаны 2022 оны 6 сарын 15-ны өдрийн А/06 тушаал, тоот бичгээр өгсөн заавар зөвлөмжийн дагуу тус тус хуваарилсан байна.

2.3 Аймгийн сонгуулийн хороо болон сумдын сонгуулийн хороо нь баталсан төсвийн хүрээнд зардал тус бүрд нь СЕХ-оос өгсөн албан бичиг болон

Сонгуулийн Ерөнхий Хорооны 2021 оны 3 дугаар сарын 19-ны А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын дагуу тооцож хуваарилсан байна.

БҮЛЭГ Б Улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хэмнэлттэй зарцуулсан байна.

3. Баталсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.



3.1 Сумын ИТХ-н 2022 оны нөхөн сонгуулийг зохион байгуулахад 68.1 сая төгрөг баталж 62.0 сая төгрөг зарцуулж 6.1 сая төгрөг хэмнэж Сонгуулийн ерөнхий хороонд төвлөрүүлсэн байна.


График №-2 Сумдын ИТХ-ын 2022 оны нөхөн сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны зардлын хэмнэлт /сая.төгрөг/



Эх сурвалж: Аймгийн нөхөн сонгуулийн хорооны 2022 оны тайлан

3.2 Дээрх графикаас харахад аймаг, сумдын ИТХ-н 2022 оны нөхөн сонгуулийн үйл ажиллагааны зардлыг аймгийн сонгуулийн хороо 5.8 сая төгрөг, сумдын сонгуулийн хороо 0.3 сая төгрөг тус тус хэмнэж ажилласан байна.

График №-3 Сумдын ИТХ-н 2022 оны нөхөн сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны зардлын хэмнэлт аймаг, сумд /сая.төгрөг/



3.3 Сумдын ИТХ-н 2022 оны нөхөн сонгууль зохион байгуулахад Номгон сумын сонгуулийн хороо 0.1 сая, Даланзадгад сумын сонгуулийн хороо 0.1 сая төгрөг тус тус хэмнэсэн бол аймгийн сонгуулийн хороо 5.8 сая төгрөгийг хэмнэж ажилласан байна.

Хүснэгт №-3 Сумдын ИТХ-ын 2022 оны нөхөн сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны хэмнэлт гарсан зардал /сая.төгрөг/

№	Зардлын нэр	Төсвийн хэмнэлт
1	Шуудан холбооны зардал	0.2
2	Унааны зардал	2.2
3	Санал авах байр, төрийн далбаа бэлтгэх зардал	0.1
4	Саналын хуудас ICP төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх унааны зардал	0.1
5	Сурталчилгааны зардал	0.1
6	Томилолтын зардал	0.9
7	Болзошгүй зардал	2.5
Нийт		6.1


Эх сурвалж: Аймгийн нөхөн сонгуулийн хорооны 2022 оны тайлан

Аймгийн сонгуулийн хороо нь 7 төрлийн зардлаас хэмнэгдсэн 6.1 сая төгрөгийг СЕХ-д төвлөрүүлсэн байна.

4. Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.

4.1 Сумдын ИТХ-ын 2022 оны нөхөн сонгууль зохион байгуулахад аймаг, сумдын сонгуулийн хороонд 68.1 сая төгрөгийн төсөв баталснаас 62.0 сая төгрөгийг зарцуулж 91%-ийн гүйцэтгэлтэй гарсан байна.

График №-4 Сумдын ИТХ-ын 2022 оны нөхөн сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэл /Сая.төгрөг/



Эх сурвалж: Аймгийн сонгуулийн хорооны 2022 оны тайлан

4.2 Дээрх графикаас харахад аймгийн хэмжээнд сумдын ИТХ-н 2022 оны нөхөн болон зохион байгуулахад аймгийн сонгуулийн хороо 53.9 сая төгрөг, сумдын сонгуулийн хороо 8.1 сая төгрөг, нийт 62.0 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт №-4 Сумдын ИТХ-ын 2022 оны нөхөн сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэлийн зардал

/Сая төгрөг/				
№	Зардлын нэр	Баталсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Төсвийн хэмнэлт
1	Маягт хэвлүүлэх зардал	0.1	0.1	0
2	Үнэмлэх хэвлэх зардал	0.2	0.3	0
3	Сонгуулийн хорооны сургалтын зардал	0.8	0.7	0
4	МТБ, даамлын сургалтын зардал	0.1	0.1	0
5	Бичиг хэргийн зардал	1.6	1.6	0
6	Шуудан холбооны зардал	2	1.8	0.2
7	Унааны зардал	6.3	4.1	2.2
8	Санал авах байр бэлтгэх зардал	1.5	1.3	0.1
9	Саналын хуудас, ICP төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх унаа, томилолтын зардал	7.6	7.4	0.1
10	МТБ-ийн мэдээ дамжуулах холбоо, унааны зардал	0.2	0.3	0
11	САС ашиглах холбоотой гарах зардал /Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх/	0.4	0.4	0
12	Мэдээ дамжуулах унааны зардал	0.3	0.4	0
13	Сурталчилгааны зардал	3	2.9	0.1
14	Томилолтын зардал	3.9	3	0.9
15	Сонгуулийн хорооны гишүүний урамшуулал, хоолны зардал	32	32	0
16	Мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	5.6	5.6	0
17	Болзошгүй зардал	2.5	0	2.5
НИЙТ		68.1	62	6.1

Эх сурвалж: Аймгийн нөхөн сонгуулийн хорооны 2022 оны тайлан

4.3 Сумдын сонгуулийн хорооны 68.1 сая төгрөгийн баталсан төсвөөс 62 сая төгрөгийн зарцуулж 17 төрлийн зардлаас 7 зардлын гүйцэтгэл 6.1 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.

Хүснэгт №-5 Сумдын ИТХ-ын 2022 оны нөхөн сонгууль байгуулах үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэл

/Сая төгрөг/				
№	Сумдын нэр	Баталсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Төсвийн хэмнэлт
1	Баян-Овоо сумын сонгуулийн хороо	1.7	1.7	0
2	Булган сумын сонгуулийн хороо	1.7	1.7	0
3	Мандал-Овоо сумын сонгуулийн хороо	1.7	1.7	0
4	Номгон сумын сонгуулийн хороо	1.7	1.6	0.1
5	Даланзадгад сумын сонгуулийн хороо	1.5	1.4	0.1
6	Аймгийн сонгуулийн хороо	59.8	53.9	5.9
НИЙТ		68.1	62	6.1

Эх сурвалж: Аймгийн нөхөн сонгуулийн хорооны 2022 оны тайлан

4.4 Сумдын ИТХ-н 2022 оны нөхөн сонгуулийг зохион байгуулах үйл ажиллагааны зардлын гүйцэтгэлийг Аймгийн сонгуулийн хороонд үнэн зөв бүрэн гүйцэт мэдээлэн, санхүүгийн тайлангийн хамт хүргүүлсэн байна.

4.5 Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны 5 дугаар сарын 11 -ны А/368 дугаар тушаалаар Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгууль нөхөн зохион байгуулахтай холбогдуулсан зардлыг Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст 7.3 сая төгрөгөөр баталсан байна.



Хүснэгт №-6 Сумдын ИТХ-ын нөхөн сонгуулийн Улсын бүртгэлийн хэлтсийн зардал /сая.төгрөг/

№	Аймаг	Сонгуульд ажиллах ажилтны мөнгөн урамшуулал, хоол, унааны зардлын төсөв	Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх	Сонгогчдын нэрийн жагсаалт хүргэх	Томилолт унааны зардал	Техник хэрэгслийн тээвэрлэх зардал	Нийт
1	Өмнөговь Улсын бүртгэлийн хэлтэс	3.8	0.5	0.5	0.5	2	7.3

Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны А/368 тушаал

4.6 Улсын бүртгэлийн хэлтэс нь 2022 оны ИТХ-ын нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор техник хэрэгсэл тээвэрлэх болон сургалтын зардлаас 0.3 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулаагүй буюу Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны А/368 тушаалаар баталсан орон нутаг дахь Улсын бүртгэлийн газар, хэлтэст хуваарилсан зардлын төсвийн дагуу зарцуулаагүй байна.

4.7 Цагдаагийн ерөнхий газраас Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газарт сумдын ИТХ-ын нөхөн сонгууль болохтой холбоотойгоор 0.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Хүснэгт №-7 Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газрын 2022 оны сумдын ИТХ-ын нөхөн сонгуулийн зардал /Сая төгрөг/

№	Байгууллагын нэр	Шуудан холбооны зардал	Хоолны зардал	Шатахууны зардал	Нийт
1	Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газар	0.1	0.3	0.5	0.9

4.8 Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газар нь сумдын ИТХ-ын нөхөн сонгуулийн хамгаалалтад гарсан 12 албан хаагчдад шуудан холбооны зардал 0.1 сая төгрөг, хоолны зардал 0.3 сая төгрөг, автомашины шатахууны зардал 0.5 сая төгрөг, нийт 0.9 сая төгрөг зарцуулан сонгуулийн зардлын тайланг гаргаж Цагдаагийн ерөнхий газрын санхүү аж ахуйн албанд хүргүүлсэн байна.

Дүгнэлт

Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд хийсэн аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- ✓ СЕХ нь Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын дагуу аймаг, сумын ИТХ-ын сонгуулийн зардлыг тооцож олгосон байна.
- ✓ Аймгийн сонгуулийн хороо нь сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын дагуу сумдын сонгуулийн хорооны зардлыг тооцож хуваарилсан байна.
- ✓ Сумдын ИТХ-н 2022 оны нөхөн сонгуулийг зохион байгуулахад 68.1 сая төгрөг баталж, гүйцэтгэлээр 62.0 сая төгрөг зарцуулж 6.1 сая төгрөгийг хэмнэж СЕХ-нд төвлөрүүлсэн байна.

Аудитын зөвлөмж

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Улсын бүртгэлийн хэлтэст

- Төсвийн тухай хуулийн 6.4.1 төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаалаар баталсан зардлыг төсвийн дагуу зарцуулах

Тайлан баталгаажуулах тушаал



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2022 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/18

Даланзадгад сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам” –ын 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн Хурлын нөхөн сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэл” –д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитын тайланг Аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлсүгэй.

3. Аудиттай холбоотой ажлын болон нотлох баримтыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, аудитын тайланг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтэд түгээхийг гүйцэтгэлийн аудитын баг (Ч.Наранбадрах)-д үүрэг болгосугай.



Ц.ӨСӨХБАЯР